



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД Л.ЦЭДЭВСҮРЭН
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛТ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
http://www.parliament.mn

2020.10.08 № 24

Асуулт тавих тухай

Хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хүчирхийллийг эрт шатанд нь илрүүлэх, дахин давтагдахаас урьдчилан сэргийлэх, хохирогчдыг хамгаалахад төрийн болон иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ажиллах, сургалт, зөвлөгөөн зохион байгуулах зэрэг ажлуудыг үр дүнтэй зохион байгуулахаар Улсын Их Хурлын нэр бүхий гишүүд “Хүчирхийлэлтэй тэмцэх” лобби бүлгийг байгуулан ажиллаж байна.

Монгол Улсын хэмжээнд боловсролын байгууллагууд хүүхэд хамгааллын болон хүүхдийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр холбогдох хууль тогтоомжид заасны дагуу тодорхой үүргүүдийг хүлээсэн хэдий ч бодит байдал дээр тэдгээрийг хэрэгжүүлж чадаж байгаа эсэх нь тодорхой бус байна.

Тухайлбал, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Сургалтын байгууллага хүүхэд хамгааллын бодлогыг тухайн байгууллагад хэрэгжүүлэхдээ хөтөлбөр, төлөвлөгөө гарган, мөрдөж ажиллана” гэж, мөн зүйлийн 6.3.2-т “сургалтын байгууллагын багш, ажилтан суралцагчдын эрсдэлт нөхцөлд байгаа эсэхийг үнэлэх, судлах, зөвлөгөө өгөх” гэж тус тус заасан. Түүнчлэн Бага, дунд боловсролын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.9-д заасны дагуу багш нь “хүчирхийлэлд өртсөн, өртөж болзошгүй хүүхдийг илрүүлэх, холбогдох байгууллагад мэдээлэх, хуульд заасан үйлчилгээнд хамруулахад дэмжлэг үзүүлэх” гэж, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.1-д заасны дагуу “бүх шатны боловсролын байгууллагын багш, сургуулийн нийгмийн ажилтан, бусад ажилтан” нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдсэн, эсхүл үйлдэгдэж болзошгүй нөхцөл байдлын талаар олж мэдсэн бол хуульд заасан холбогдох байгууллага, албан тушаалтнуудад мэдэгдэх үүрэг хүлээсэн байна.

Дээрх хуулийн зохицуулалтаас үзэхэд багш болон сургуулийн нийгмийн ажилтан нь хүүхдийн эсрэг хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсооход онцгой чухал үүрэг гүйцэтгэхээр байна. Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, 39 дүгээр зүйлийн 39.1.2-т тус тус заасны дагуу Танд дараах асуултыг тавьж байна. Үүнд:

2020000049

1. Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа ерөнхий боловсролын сургуулиуд хүүхэд хамгааллын хөтөлбөр, төлөвлөгөө гаргаж, мөрдөж ажиллаж байгаа эсэх талаар;
2. Сурагчид эрсдэлт нөхцөлд байгаа эсэхийг үнэлж, тэдгээрт хэрэгцээтэй зөвлөгөө өгөх, үйлчилгээ үзүүлэх үүргээ хэрэгжүүлж байгаа эсэх талаарх мэдээлэл;
3. Сургуулийн нийгмийн ажилтнууд хүчирхийлэлд өртөж болзошгүй хүүхдийн бүртгэл, мэдээллийг хөтөлж, шалтгаангүй хичээл таслалт, хоцролтын шалтгааныг судлах зэргээр хүүхдийг хүчирхийлэлд өртөхөөс сэргийлэх чиглэлээр ажиллаж байгаа байдлын талаар;
4. Сургуулийн эмч нар эрүүл мэндийн үзлэгийг тогмтол явуулж, хүүхдийн биед гадны нөлөөллөөр үүссэн шарх, сорви илэрсэн тохиолдолд бүртгэлжүүлж, холбогдох байгууллагуудад мэдээлж байгаа эсэх талаар;
5. Сургуулийн боловсролын агуулгад хүчирхийллээс урьдчилан сэргийлэх болон зөрчлийг хүчирхийллийн бус аргаар шийдвэрлэх, эрсдэлээс өөрийгөө хамгаалах мэдлэг, харилцааны ур чадвар олгох зорилтыг хэрхэн хэрэгжүүлж байгаа байдлын талаарх мэдээлэл;
6. Боловсролын байгууллагын багш, нийгмийн ажилтны зүгээс хүчирхийлэлд өртсөн болон хүчирхийлэлд өртөж болзошгүй хүүхдийг илрүүлж, хэчнээн тооны мэдээллийг аль байгууллага, албан тушаалтанд гаргасан талаарх мэдээлэл зэрэг болно.

Асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.8 дахь хэсэгт заасан хугацаанд ирүүлэхийг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



Х.ГАНХУЯГ

2020000049